

ЭМИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ 5 АЛХАМ

Энэхүү бичиг баримтад орсон мэдээллийг баталгаажуулахын тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зүгээс боломжит бүх арга хэмжээг авсан ба тус материал нь ямар нэгэн илэрхий болон далд утга агуулалгүйгээр тараагдсан болно. Бичиг баримтын орчуулга болон хэрэглээтэй холбоотой гомдол нь хэрэглэгчийн хариуцлагын асуудал бөгөөд хэрэглээтэй холбоотой ямар нэгэн хохирол үссэн тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хариуцлага хүлээхгүй.

ДЭМБ/HIS/SDS/2019.5
© Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2019. Зарим эрх хуулиар хамгаалагдсан. CC BY-NC-SA 3.0 IGO лицензийн дагуу энэ материалыг авах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаас авна уу:

<https://www.who.int/patientsafety/medication-safety/5moments/en/>



Эмийг зөв хэрэглэх 5 алхам гэдэг нь үйлчлүүлэгч эсвэл түүний гэр бүлийнхэн, асран хамгаалагчийн оролцоотойгоор эмийн хэрэглээтэй холбоотой үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн түлхүүр зарчим юм. Алхам тус бүр нь 5 чухал асуултаас бүрдэнэ. Зарим асуултад үйлчлүүлэгч бие даан хариулах боломжтой бол заримыг нь ойлгож, зөв хариулахын тулд эмнэлгийн мэргэжилтний тусlamж шаардлагатай.

ДЭМБ-ын зүгээс үйлчлүүлэгчийн оролцоог тусгасан энэхүү зөвлөмжийг Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн III дугаар аяны хүрээнд "Эмийн зөв хэрэглээ" уриан дор боловсруулан гаргасан.

Энэхүү зөвлөмж нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндээ хамгаалахад илүү идэвхтэйгээр татан оролцуулах, эмийн талаарх мэдээлэлд тэдний анхаарлыг хандуулах, "Эмийн зөв хэрэглээ"-ний талаар эмнэлгийн мэргэжилтнүүдтэй нээлттэй харилцах боломжоор хангахад чиглэсэн юм.

Зөвлөмжийг үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт зориулан боловсруулсан ба хэрэгжүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнүүдийн дэмжлэг, хамтын ажиллагаа шаардлагатай.



Үйлчлүүлэгч болон тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт

Эмийг хэрэглэхдээ дараах 5 АЛХАМ-ыг хэрэгжүүлээрэй.

- Эмч, сувилагч, эм зүйч, шүдний эмчид үзүүлэх;

• Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага, эмийн сангаар үйлчлүүлэх;

- Эмнэлэгт хэвтэх, эмнэлгээс гарах;

• Өөр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх;

• Нэг эрүүл мэндийн байгууллагаас нөгөөд шилжин үйлчлүүлэх;

• Гэрийн болон өдрийн эмчилгээ, үйлчилгээ авах бүрт Та дараах асуултуудыг асууж; эмнэлгийн мэргэжилтний тусlamжтайгаар хариултаа аваарай.



Эмнэлгийн мэргэжилтнүүдэд

Эмийг зөв хэрэглэх 5 алхамын талаар үйлчлүүлэгч,

тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт танилцуулан, асуултад хариулах замаар үйлчлүүлэгчийн оролцоог дэмжээрэй.



ЭМИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ 5 АЛХАМ

ЭМИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ 5 АЛХАМ



1 Эм хэрэглэхийн өмнө

- ▶ Энэ эмийн нэр нь юу вэ, ямар үйлчилгээтэй вэ?
- ▶ Энэ эмийг хэрэглэхэд илэрч болох гаж нөлөө нь юу вэ?
- ▶ Миний өвчин, эмгэгийг эмчлэх өөр арга бий юу?
- ▶ Харшил болон бусад өвчин, эмгэгийнхээ талаар эмнэлгийн мэргэжилтэнд хэлсэн үү?
- ▶ Энэ эмийг хэрхэн зөв хадгалах вэ?

2 Эм хэрэглэх үед

- ▶ Энэ эмийг хэзээ, ямар тун хэмжээгээр хэрэглэх вэ?
- ▶ Энэ эмийг хэрхэн зөв хэрэглэх вэ?
- ▶ Энэ эмийг хэрэглэж байх үед хоол хүns болон уух зүйлтэй холбоотой анхаарах зүйлс байна уу?
- ▶ Эмээ цагт нь хэрэглээгүй тохиолдолд яах ёстой вэ?
- ▶ Эмийн гаж нөлөө илэрвэл яах ёстой вэ?

3 Нэмэлт эм хэрэглэх үед

- ▶ Надад өөр эм нэмж хэрэглэх зайлшгүй шаардлага байгаа юу?
- ▶ Тогтмол хэрэглэдэг эмийнхээ талаар эмнэлгийн мэргэжилтэнд хэлсэн үү?
- ▶ Энэ эм нь миний хэрэглэдэг бусад эмтэй зохицох уу?
- ▶ Хэрэглэх шаардлагагүй болсон эмийг хэрэглэсээр байна уу?
- ▶ Эмнэлгийн мэргэжилтэн миний хэрэглэж байгаа эмийг тогтмол хянадаг уу?
- ▶ Хэрэглэж байгаа эмээ эмнэлгийн мэргэжилтнээр ямар давтамжтай хянуулах шаардлагатай вэ?

4 Хэрэглэж байгаа эмээ хянах үед

- ▶ Миний хэрэглэж байгаа бүх эмийн мэдээлэл надад байна уу?
- ▶ Эм тус бүрийг хэр удаан хэрэглэх ёстой вэ?
- ▶ Хэрэглэх шаардлагагүй болсон эмийг хэрэглэсээр байна уу?
- ▶ Эмнэлгийн мэргэжилтэн миний хэрэглэж байгаа эмийг тогтмол хянадаг уу?
- ▶ Хэрэглэж байгаа эмээ эмнэлгийн мэргэжилтнээр ямар давтамжтай хянуулах шаардлагатай вэ?

5 Эмийн хэрэглээг зогсоох үед

- ▶ Хэрэглэж байгаа эмээ хэзээ зогсоох хэрэгтэй вэ ?
- ▶ Миний хэрэглэж байгаа эмнүүдээс шууд зогсоож болохгүй эм байгаа юу?
- ▶ Эм дуусвал яах ёстой вэ?
- ▶ Эмийн гаж нөлөөнөөс болж эмээ хэрэглэхгүй тохиолдолд би хэнд мэдэгдэх ёстой вэ?
- ▶ Үлдэгдэл эсвэл хугацаа нь дууссан эмийг яах ёстой вэ?